



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



2020 он

ТАНИЛЦУУЛГА

“Экосум” нь байгаль орчин, хамтын нэгдэлд тулгуурласан орон нутгийн бие даасан байдал, эерэг шилжилтийн төлөөх Монгол төрийн бус байгууллага юм. Хишиг-Өндөр суманд байгуулагдсан тус байгууллага сумынхаа иргэдийн оролцоог нэмэгдүүлж, хамтын хүчээр орон нутгийн бие даасан, тэсвэртэй, дасан зохицох чадвар өндөртэй загвар сум болохыг зорин ажиллаж байна.

Энэхүү тайлан нь Экосум ТББ дээр дурдсан зорилгодоо хүрэхийн тулд 2020 онд хийсэн ажлуудын мэдээллийг товч агуулсан болно.

Дэлхий дахинд тархсан Ковид-19 цар тахлаас үүдсэн нөхцөл байдал, хөл хорионы улмаас зарим төлөвлөсөн ажлууд цуцлагдаж, зарим нь хойшлогдов. Гэвч бидний хогны менежментийн төсөл маань бодитой үр дүнтэй урагшилж байна. Бусад төслүүд 2021 он хүртэл хүлээгдэж байна.

ХОГНЫ МЕНЕЖМЕНТ

ЭКОСУМ-ЫН ЗОРИЛГО НЬ ХИШИГ-ӨНДӨР СУМЫГ ХОГГҮЙ СУМ БОЛГОХЫН ТУЛД ХОГ АНГИЛАЛТ, ДАХИН БОЛОВСРУУЛАЛТЫГ НЭВТРҮҮЛЖ, ҮР АШИГТАЙ, ТОГТВОРТОЙ ХОГНЫ МЕНЕЖМЕНТИЙГ БИЙ БОЛГОХ

ХОГНЫ МЕНЕЖМЕНТИЙН СУДАЛГАА

2019 оны зун хийсэн өрхийн хог хаягдлын бүтцийн судалгаанаас хойш улирлын хамаарал, ялгааг нарийвчлан гаргаж, өмнөх судалгааны үр дүнг бататгахын тулд өвлийн хогны бүтцийн судалгааг мөн хийв. Мөн Хишиг-Өндөр сумаас Улаанбаатар хотын дахин боловсруулах үйлдвэрүүд рүү дахивар түүхий эд тээвэрлэлтийн боломж, хувилбаруудыг харьцуулсан нэмэлт судалгааг мөн хийлээ.



2020 оны сүүлийн хагаст Хишиг-Өндөр сумын хог хаягдалтай холбоотой, шаардлагатай бүхий л мэдээллийг нэгдсэн нэг тайланд багтаахаар илүү өргөн хүрээг хамарсан судалгаануудыг хийсэн. Энэ

судалгаанд Хишиг-Өндөр сумын төвийн өрхүүдээс гадна сумын малчин өрхүүд, төсвийн байгууллагууд, хувийн худалдааны байгууллагууд гээд сумын бүхий л хог үүсгэгчдийг хамруулав. 2020 оны 12 сарын сүүлийн байдлаар тайланг нэгтгэхэд зарим нэг мэдээлэл дутуу байгаа бөгөөд 2021 оны 1 сард тус тайланг бэлэн болгохоор төлөвлөсөн байна. Энэхүү тайланд сумын хогны менежментийг сайжруулах, зохистой менежментийн талаарх зөвлөмжийг мөн багтаах болно.

Үүнтэй ижил судалгаа, тайланг аймгийн хэмжээнд мөн 2021 онд хийхээр төлөвлөж байна.

Экосум ТББ-ын 2018 оноос хойш гаргасан бүх судалгаа, тайлангуудыг байгууллагын цахим хуудаснаас үзэх боломжтой (www.ecosoum.org).

ДАХИН БОЛОВСРУУЛАХ МАШИН

2019 онд бид хуванцар дахин боловсруулах жижиг оврын бутлагч, хайлуулж хэвэнд цутгах үйлдэлтэй 2 машиныг барьж байв. Эдгээр машинууд нь хуванцар дахин боловсруулах боломжтойг олон нийтэд харуулах үндсэн зорилготой бөгөөд сумын хэмжээнд ашиглахад хүчин чадал нь хүрэлцэхгүй юм. Иймээс 2020 онд орон нутгийн иргэд хог хаягдлаа тогтвортой ангилж эхлэх үед сумандаа дахин боловсруулах зорилготойгоор шил, хуванцар бутлах 2 ширхэг үйлдвэрийн тоног төхөөрөмжийг худалдаж авсан. 2021 онд хуванцар хайлуулж, хэвэнд цутгах нэмэлт машинуудыг худалдан авах, цаашилбал орон нутгатаа хийхээр төлөвлөсөн байгаа.



ӨРХИЙН ХОГ АНГИЛАХ САВ ҮЙЛДВЭРЛЭЛ

Сумын төвийн айл өрхүүд хог хаягдлаа зөв зүйтэй, тогтвортой ангилахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байх хэрэгтэй гэсэн үүднээс бид өрхийн хог ангилах савыг сумын ЗДТГ-ын захиалгаар эхний 30 ширхэгийг үйлдвэрлэв. Тэдгээрийг Экосум ТББ-ын баг хамт олон зураг төсвийг гаргаж хийсэн бөгөөд 2021 оны эхээр хог хаягдлаа ангилах хүсэлтэй 30 өрхөд тарааж өгөх юм. Дараагийн савнуудыг тасралтгүй үйлдвэрлэхийн тулд шаардлагатай түүхий эдийг худалдаж аваад байна.



ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ СУРГАЛТ

Хишиг-Өндөр сумын иргэд, байгууллагуудад хог хаягдалтай холбоотой сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулахаар төлөвлөсөн бидний ажил Ковид-19 цар тахлын улмаас боломжгүй болов. Гэвч бид хамтрагч байгууллагууд болох Каритас Чех Репаблик болон Монголын Тогтвортой Хөгжлийн Гүүр ТББ-уудын хамтаар онлайн сургалтыг 100 оролцогчтойгоор амжилттай зохион байгуулж чадсан. 2021 онд нэмэлт онлайн сургалтуудыг явуулахаар төлөвлөөд байна.

Бид нэмэлт хог хаягдлын тухай сургалтын материал, видео бэлдэж эхлэсэн бөгөөд 2021 оны эхээр бэлэн болгож олон нийтэд хүргэнэ.

ХОГИЙН ЦЭГИЙН ТАЛБАЙГ ХУМИХ, ЦЭВЭРЛЭХ АЖЛЫН ЗӨВЛӨГӨӨ, ДЭМЖЛЭГ

Хишиг-Өндөр сумын төвлөрсөн хогийн цэгийн талбай маш ихээр тэлж, хүрээлэн буй орчныг бохирдуулж байгаа тул юун түрүүн хогийн цэгийг хумих шаардлагатай тухай сумын удирдлагуудад

зөвлөсний дагуу Булган аймгаас тус ажилд зориулсан төсвийг гаргаж өгөв. Дээрх ажлыг гүйцэтгэх компанийг олон нийтэд нээлттэй сонгон шалгаруулах явцад манай байгууллага зөвлөгөө өгч, ажил үүргийн хуваарийг нарийвчлан гаргахад оролцов. Мөн ажлын гүйцэтгэлтэй танилцаж, тус ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Тосон Бумбын Орон” ХХК-н ажилчидтай ажлын төлөвлөгөөн дээр санал солилцож, байр сууриа илэрхийлэв. Ковид-19 өвчний улмаас улс даяар хөл хорио тогтоосон тул тус ажил зогссон бөгөөд 2021 онд дуусгахаар төлөвлөсөн байна.

